



54

СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар

11/15

Хуурч

Г Баярын өдрүүдэд урьдчилан сэргийлэх
ажлыг сайжруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-н "а", "л", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2021 оны "Халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай" 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цагаагчин үхэр жилийн сар шинийн баярыг нийтээр тэмдэглэхгүй байхаар шийдвэрлэсэн Засгийн газрын тогтоолыг мөрдөж айлд зочлохгүй, зочин урихгүй, гэр гэртээ шинэлэхийг сумын нийт иргэдэд уриалж, тогтоолыг хэрэгжүүлж хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.


2.Баярын өдрүүдэд сумын Гамшгаас хамгаалах штабын хариуцлагатай эргүүл жижүүр, бүдүүний гүүрний постод ажиллах ажилтнуудыг үүрэгжүүлж, гэрийн ажиглалтад байгаа иргэдийн халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, хяналт тавьж ажиллахыг Гамшгаас хамгаалах штабын дарга /Д.Алтанзориг/-т даалгасугай.

3. 2 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд хариуцлагатай эргүүл жижүүр гаргаж ажиллахыг төсвийн байгууллагын захирал эрхлэгч нарт, дулааны төвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ-ын Цагааннуур хэсгийн механик /Ц.Эрдэнэчулуун/-д, Сумын цахилгаан эрчим хүчний хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Дархан Сэлэнгийн ЦТС ХК-ийн Цагааннуур хэсгийн техникч /Д.Цогтбаатар/ нарт үүрэг болгосугай.

4.Баярын өдрүүдэд сумын хэмжээнд иргэдийн аюулгүй байдлыг хангаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналтыг эрчимжүүлж ажиллахыг хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад /Т.Ганбат/-д даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээ тайланг холбогдох газарт шуурхай хүргэж ажиллахыг Засаг даргын орлогч /Б.Ууганбаяр/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.БАЯНБААТАР



0000016